



**ТӨВ АЙМГИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 21

Зуунмол

Г

Г

Тариф батлах тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн хуралдаанаас Тогтоох нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бат Комплект” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Сэргэлэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг 1 дүгээр, хэрэглээний халуун усны тарифыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг Захиргааны Хэм Хэмжээний Актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Бат Комплект” ХХК-ийн захирал (Х.Цэрэнбат)-д үүрэг болгосугай.

3.Хэрэглэгч хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн (Ц.Оюунчимэг)-д даалгасугай.

ДАРГА


Г.СУРМАА

ГИШҮҮН

Ц.ОЮУНЧИМЭГ



Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын
05-ний өдрийн 277 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт




**“БАТ КОМПЛЕКТ” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН СЭРГЭЛЭН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

Төв аймгийн “Бат комплект” ХХК-НИЙ эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Сэргэлэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын дулааны тариф	Төг/м3	2250.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагын дулааны тариф	Төг/м3	1200.0

--- оОо ---

Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын
05-ний өдрийн 24 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт



**“БАТ КОМПЛЕКТ” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН УСНЫ
ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН СЭРГЭЛЭН СУМЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ХЭРЭГЛЭЭНИЙ
ХАЛУУН УСНЫ ТАРИФ**

Төв аймгийн “Бат комплект” ХХК-НИЙ эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Сэргэлэн сумын хэрэглэгчдэд борлуулах хэрэглээний халуун усны тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын хэрэглээний халуун усны тариф	Төг/м3	2900.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагын хэрэглээний халуун усны тариф	Төг/м3	2900.0

--- оОо ---